

Сумын 3-р сургуулийн Хүүхдийн зөвлөлийн сурагчид 2017 оны 10 сарын 21-ний өдөр сумандаа Хүүхдийн чуулганыг зохион байгууллаа.

“Хүүхдийн чуулган”-д 200 гаруй зочид төлөөлөгчид оролцож, Сумын Засаг дарга, сургуулийн удирдлагууд, сумын нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн нар чуулганы насанд хүрэгчдийн төлөөлөл болж зочноор оролцож, хөтөлбөрийн дагуу Шивээговь сумын оролцооны 14 бүлгийн сурагчид тангараг өргөж, чуулганыг эхлүүллээ.

Чуулганы үеэр сумын удирдлагын зүгээс аймгийн тэмцээн, уралдаануудад амжилттай оролцсон 10 сурагчийг шагнаж урамшуулж, “Хариу нэхээгүй тус” аянд идэвхтэй оролцсон 3 ангийг Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа.

Шилдэг сурагч медаль, үнэ бүхий зүйлээр:

1. 12^б ангийн сурагч Б.Оюунтунгалаг
2. 12^б ангийн сурагч Ч.Нямжаргал
3. 12^б ангийн сурагч Э.Цэнд-Аюуш
4. 11^а ангийн сурагч У.Хонгорзул
5. 9^а ангийн сурагч П.Ундрах
6. 9^б ангийн сурагч Э.Цэцэгчимэг
7. 10^а ангийн сурагч Г.Наранцэнгэл
8. 9^б ангийн сурагч М.Ундрал
9. 9^б ангийн сурагч Э.Мөнгөнсондор
10. 7^а ангийн сурагч Г.Оюумаа



Хариу нэхээгүй тус аяны Шилдэг ангиар:

1. Н.Чулуунчимэг багштай 6^а анги
2. Ч.Дэжидмаа багштай 7^а анги
3. Ж.Баярцэцэг багштай 9^а анги тус тус шагнал гардан авсан.



Чуулганы үеэр 2017-2018 оны хичээлийн жилийн сурагчийн мөрдөх 5 дэгийг оролцогч хүүхдүүдээр хэлэлцүүлж, баталсан. Үүнд:

1. Мэндлэх хүндлэх дээдлэх ёсыг эрхэмлэх
2. Зорилготой, сурах эрмэлзэлтэй байх
3. Хорт зуршил, муу үйлээс татгалзах
4. Сургуулийн эд хогшлыг хайрлан хамгаалах
5. Эрүүл аж төрөх ёсыг эрхэмлэн сахих

Чуулганыг өртөөчилсөн байдлаар зохион байгуулж, чиглүүлэгч сурагчид анги, бүлгийн сурагчдыг өртөөгөөр хөтөлж, аялуулан сургагч сурагчид хүүхдийн эрх, үүрэг, хөгжих гарцыг нээсэн олон зорилтот сургалтуудыг зохион байгууллаа.

Үүнд:

1-р өртөө “Цахим орчинд бид” өртөөгөөр цахим гадуурхал үндэсний хөтөлбөрийн зорилго, цахим орчинд хэрхэн зөв боловсон оролцох талаар мэдлэгийг сурагчдад олгов.

2-р өртөө “Лидер сурагч-академи” өртөөгөөр академийн танилцуулгыг сурагчдад танилцуулж, сургуульдаа хэрэгжүүлэх шинэлэг санал санаачлагыг сурагчдаас авсан.

3-р өртөө “Эрх ба үүрэг” өртөөгөөр хүүхдийн холбогдох хуулиудын танилцуулга, шторкыг сурагчдад үзүүлж, хүүхдийн үүргийг тодруулан танилцууллаа.

4-р өртөө “Тоглоом” өртөөгөөр сурагчдын дунд 3 төрлийн хөгжөөнт тоглоом зохион байгуулсан.

5-р өртөө “Бидний дуу хоолой” өртөөгөөр сурагчдын санал хүсэлтийг авч, нэгтгэсэн.

6-р өртөө “Амжилтын эхлэл” өртөөгөөр Дэлхийн алдартай хүмүүсийн амьдрал, замналыг сурагчдад танилцуулсан.



7-р өртөө “Амьдралын сургамж” өртөөгөөр сургамжит өгүүллэгүүдийг сурагчдад уншиж танилцуулж, тэдний санал бодлыг солилцсон.

8-р өртөө “Амралт” өртөөгөөр сурагчдын алжаалыг тайлах хөгжөөнт дасгал хийлгэж, ус, жигнэмэгээр үйлчилсэн.

9-р өртөө “Харилцаа” өртөөгөөр хувь хүний харилцаа хандлага, мэндлэх хүндлэх ёсны талаар сургалт зохион байгуулсан.

10-р өртөө “Оролцъё, хөгжъё” өртөөгөөр сурагчдын хөгжил оролцоог нэмэгдүүлэх дугуйлан секцийн танилцуулгыг хийсэн.

